



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын хорин дөрөвдүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/27/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН СУМЫН 24 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.СУВДАНЧИМЭГ ТАНАА

2022.02.25 № 146
танай -ны № -т



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009020240

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	44,866,289.96	44,672,588.10
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,771,376,065.01	1,741,297,401.73
	Нийт хөрөнгийн дүн	1,816,242,354.97	1,785,969,989.83
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,816,242,354.97	1,785,969,989.83
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,816,242,354.97	1,785,969,989.83
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	388,796,911.75	407,881,100.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	413,340,651.92	438,153,465.14
	Үйл ажиллагааны үр дүн	(24,543,740.17)	(30,272,365.14)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(116,100.00)	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(24,659,840.17)	(30,272,365.14)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,836,325,060.14	1,816,242,354.97
	Тайлант оны үр дүн	(20,082,705.17)	
	Эцсийн үлдэгдэл	1,816,242,354.97	1,816,242,354.97
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	381,285,100.00	407,881,100.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	378,109,100.00	389,832,100.00
	Үйл ажиллагааны ЦМГ	8,601,000.00	18,049,000.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(8,601,000.00)	(18,049,000.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	408,814,200.00	407,352,100.00
	Урсгал зардал	408,814,200.00	389,303,100.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	408,814,200.00	407,352,100.00
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	371,364,200.00	371,364,200.00
	Орон нутгийн төсвөөс	37,450,000.00	35,812,900.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		175,000.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус цэцэрлэг нь Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Дархан-Уул аймгийн Засаг даргын 2014 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 388 тоот захирамжаар Дархан сумын 12 дугаар багийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэн 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ашиглалтад орсон.

Дархан сумын 24-р цэцэрлэг нь 2015 оны 12 сарын 22-нд Дархан-Уул аймгийн засаг даргын 391-р захирамжаар Дархан сумын 12-р багийн нутаг дэвсгэр “Хүслийн хотхон”-д байгуулагдсан.

2019 онд 100 хүүхдийн хүчин чадал бүхий өргөтгөлийн барилга баригдсан.

Тус цэцэрлэг нь одоо 200 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлэхээр Дархан сумын гэр хорооллын 12, 15-р багийн нийт 2-5 насны 8 бүлэгт нийт 200 хүүхдийг хүлээн авч сургалтын Цөм хөтөлбөрийн дагуу сургалт үйл ажиллагааг тасралтгүйгээр явуулж 30 багш ажилтны орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа. Санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол

Сангийн сайдын 2021 оны 190 тус тус шинээр мөрдөгдөж эхэлсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Дархан сумын 24 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 30,045.5 мянган төгрөгийн 26 нэр төрлийн хөрөнгө болон улсын бүртгэлийн гэрчилгээнд 178,850.0 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдалд дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

Аудитаар нийт 434.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Татварын албанд бүртгэлтэй хуримтлагдсан 434,640.10 төгрөгөөр илүү төлөлтийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь өсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” ,НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;гэсэн тус тус заалт,"Тасалбар болголт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

/мянган төгрөгөөр/

[illegible]

	хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	1	434.6	-	-	-	-	-	-	1	434.6